



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН  
СУМЫН СОНГУУЛИЙН  
ХОРООНД**

2024.08.02 № 613  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Булган аймгийн Булган сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол

006021272

Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


**Дүгнэлт**

Булган аймгийн Булган сумын Ардчилсан нам Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Булган сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр (<sup>14</sup>.....хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Булган сумын Ардчилсан намд

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ



**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024 он

# АГУУЛГА

## 1. НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1. ЭРҮҮЛ МЭНД
- 1.2. ЭРДЭМ БОЛОВСРОЛ
- 1.3. НИЙГМИЙН ХАЛАМЖ ХАМГААЛАЛ

## 2. ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

- 2.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
- 2.2 ҮЙЛДВЭРЛЭЛ
- 2.3 ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ
- 2.4 ХӨДӨӨ АЖ АХУЙ
- 2.5 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

## 3. ГУРАВ. ДЭД БҮТЭЦ, ТӨВ СУУРИНГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 3.1 ЗАМ ТЭЭВЭР
- 3.2 ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ
- 3.3 БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
- 3.4 ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
- 3.5 НОГООН ХӨГЖИЛ

## 4. ДӨРӨВ. НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 4.1 ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
- 4.2 НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ
- 4.3 БАТЛАН ХАМГААЛАХ
- 4.4 ТӨСӨВ САНХҮҮ
- 4.5 ГАДААД ХАРИЛЦАА

## НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### 1.1 ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг сайжруулж, боловсон хүчнийг байнгын тогтвортой ажиллах боломжоор ханган иргэдэд хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх;

- 1.1.1 ӨЭМТ-үүдийн үйл ажиллагааны менежментийг сайжруулж хүний нөөц, тоног төхөөрөмж, стандартыг хангуулж чанар хүртээмжийг сайжруулна.
- 1.1.2 Анхан шатны үзлэг оношилгоог ӨЭМТ-д хийх нөхцөлийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлнэ.
- 1.1.3 Эрүүл мэндийн салбарын ажиллагсдыг олон улс, улс, орон нутаг, ажлын байран дахь сургалтуудад хамруулж мэдлэг, ур чадварыг сайжруулна.
- 1.1.4 Хүнс, эмийн стандартад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж аюулгүй байдлын түвшинг ахиулна.
- 1.1.5 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл аж төрөх дадал, нийгмийн эрүүл мэндийн ажил үйлчилгээг үе шаттай зохион байгуулна.
- 1.1.6 Алсын зайн оношилгоо, үйлчилгээ болох телемедициныг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.

Хүн амд хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөв, насан туршийн дадал олгохын зэрэгцээ үндэсний спорт, мэргэжлийн спорт болон багийн спортыг хөгжүүлж аймаг, улсын түвшинд өрсөлдөх чадвар бүхий багийг бүрдүүлнэ.

- 1.1.7 Уламжлалт болон олимпын спортын төрлийг дэмжин, спортын мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.
- 1.1.8 Нийтийн биеийн тамираар хичээллэх орчин бүрдүүлж, идэвхтэй дасгал хөдөлгөөнийг эрүүл амьдралын дадал, хэв маяг болгон хэвшүүлнэ.
- 1.1.9 Өвөл, зуны спортыг дэмжин материаллаг бааз техник хэрэгслийн чанар хүртээмжийг сайжруулна.

### 1.2 ЭРДЭМ БОЛОВСРОЛ

Бүх шатны боловсролыг иргэн бүр тэгш эзэмших боломж бүрдүүлж, багшлах боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлж, материаллаг баазыг сайжруулах замаар сургалтын стандарт, чанар хүртээмжийг нэмэгдүүлэн насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлэх;

- 1.2.1 Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжин чадавхжуулж, харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлэн багшийн мэдлэг боловсролыг тасралтгүй дээшлүүлж, ур чадварыг сайжруулна
- 1.2.2 Албан ба албан бус насан туршийн боловсролын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж иргэн бүрийг тэгш хамруулах замаар боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.2.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ.
- 1.2.4 Суралцагчдын суурь чадамж, бүтээлч сэтгэлгээ, авьяасыг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжиж хичээлээс гадуурх сургалт дугуйлангийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ
- 1.2.5 Хүүхэд, залуучуудын түүх, соёл, өв уламжлал, эх орноо хайрлах сэтгэлгээг хөгжүүлж, ёс зүйн зэрэг хандлагыг төлөвшүүлэн, хөдөлмөрт бэлтгэн амьдрах ухаанд сургана.
- 1.2.6 Багш суралцагчдын хөгжлийг дэмжих сургалтын танхим, кабинет, лаборатори, онлайн орчин бий болгоход дэмжлэг үзүүлнэ.
- 1.2.7 ЕБС төгсөгчдийн сурлагын чанарт анхаарч, амжилттай төгсөгчдийг гадаад дотоодын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна.
- 1.2.8 Цэцэрлэг сургуулийн хоолны чанарт хяналт тавьж шим тэжээл, амин дэмээр баялаг, стандартад нийцсэн бүтээгдэхүүнээр хангана.
- 1.2.9 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн материаллаг баазыг нэмэгдүүлэн сурч боловсрох таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ

**Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, үндэсний өв уламжлалыг түгээн дэлгэрүүлж, орчин үеийн соёл урлагийн чиг хандлагыг хослуулан хөгжүүлэх;**

- 1.2.10 Соёл урлагийн байгууллагын материаллаг баазыг нэмэгдүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх, иргэдэд соёл урлагийн үйлчилгээг тасралтгүй жигд хүргэнэ.
- 1.2.11 Иргэдийн сонирхолд нийцсэн уламжлалт арга хэмжээнүүдийг чанаржуулж, шинээр "Эвент" арга хэмжээг зохион байгуулж соёлын чиглэлээр дотоод гадаадын харилцаа, аялал жуулчлалыг хослуулан хөгжүүлнэ.
- 1.2.12 Монгол өв соёлыг хойч үедээ өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэхийн зэрэгцээ орчин үеийн соёл, урлагийн үйлчилгээг нэмэгдүүлнэ.
- 1.2.13 Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

### 1.3 НИЙГМИЙН ХАЛАМЖ ХАМГААЛАЛ

**Төрөөс үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот гэр бүлд хүргэж, халамж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн гэр бүл, хүүхэд,**

**залуучууд, ахмад настны хөгжил хамгааллыг сайжруулж, жендерийн тэгш байдлыг хангах:**

- 1.3.1 Нийгмийн халамжийн бүх төрлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж хүртээмжийг сайжруулна.
- 1.3.2 Хүн амын бүлгүүдийн нас, хүйсийн онцлогт тохирсон хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагааг судалгаанд тулгуурлан тогтмол зохион байгуулна.
- 1.3.3 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон иргэдийг төрөөс олгох санхүүгийн дэмжлэг, халамжийн хөтөлбөрт хамруулан халамжаас хөдөлмөрт шилжих бодлогыг баримталж өрх иргэнийг ядуурлаас гарахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.4 Бага орлоготой өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар хангах зорилгоор сургалт, дадлагажуулах хөтөлбөрт хамруулна
- 1.3.5 Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөж болзошгүй эрсдэлт өрх, иргэдийг хамгаалах ажлыг тогтмол зохион байгуулж нийгмийн хамгааллыг сайжруулна.
- 1.3.6 Ахмадуудын насжилтыг нэмэгдүүлэх, хөгшрөлтийг сааруулах үйл ажиллагааг зохион байгуулж нийгмийн ажил, амьдралд оролцох бололцоог нэмэгдүүлэх хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ

## **ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО**

### **2.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрны хэрэгцээг зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, ажлын байрыг бий болгоход чиглэсэн хөнгөлөлттэй зээл, боловсрол сургалтын үйл ажиллагааг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх:**

- 2.1.1 Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, бүртгэл мэдээллийг цахимжуулж сайжруулна.
- 2.1.2 Гадаад орнуудад "Дадлагажигч ажилтан бэлтгэх" хөтөлбөрт иргэдийг хамруулна.
- 2.1.3 Орон нутаг дахь МСҮТ-үүдийг түшиглэн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд хамтран ажиллана.
- 2.1.4 Орон нутгийн зах зээлийг өргөтгөх, хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлийг нэмэгдүүлэн ядуурлыг бууруулахад чиглэгдсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг бууруулан, хүн амын өсөлтийг нэмэгдүүлж, ажлын байр шинээр бий болгосон ажил олгогч, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчтэй нягт хамтран ажиллана.

- 2.1.5 Цагаар ажиллах, гэрээр ажиллах, зайнаас ажиллах гэх мэт хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэрийг дэмжих замаар эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 2.1.6 Ажил олгогч болон ажил хайгчдын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг судлан, хооронд нь холбож өгөх, харилцаанд оролцогч талуудын эрх ашгийн тэнцвэрийг хангах бодлого зохицуулалтыг хэрэгжүүлнэ.
- 2.1.7 Хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээ бүхий ажил мэргэжилтэнг бэлтгэх үйл явцыг дэмжинэ.

## 2.2 ҮЙЛДВЭРЛЭЛ

**Орон нутгийн түүхий эд, нөөц боломжид тулгуурласан, зах зээлд өрсөлдөх чадвартай, дэвшилтэт технологи бүхий нэмүү өртөг шингээсэн, олон тулгуурт эдийн засгийг бий болгож, сумынхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;**

- 2.2.1 Газар зүйн онцлог, байгалийн нөөц, баялаг, хот төлөвлөлттэй уялдуулан хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах чиглэлийн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлнэ.
- 2.2.2 Жижиг, дунд үйлдвэрлэлийн зөвлөх үйлчилгээг хөгжүүлж, төр хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 2.2.3 Бүсчилсэн хөгжлийн хүрээнд үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.
- 2.2.4 Орон нутгийн нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэлтийг төрийн худалдан авалтын бодлогоор дэмжинэ.
- 2.2.5 Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд бодлогоор санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.6 Жижиг дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад зах зээлд гарах, хил орчмын худалдаанд оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.7 Дэвшилтэт технологи инновацад суурилсан бичил үйлдвэр болон дахин боловсруулах үйлдвэр, шахмал түлшний үйлдвэрийг санхүүгийн бодлогоор дэмжиж өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

## 2.3 ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ

**Сумын худалдаа үйлчилгээний салбарын чанар, хүртээмжийг сайжруулан төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үйлчилгээний соёл, стандартыг хангуулах:**

- 2.3.1 Орон нутгийн худалдаа үйлчилгээний газруудын чанар стандарт, хангалтыг дээшлүүлж, хүн амыг гол нэр төрлийн чанартай бараа бүтээгдэхүүнээр хангах, худалдааны зохистой хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

- 2.3.2 Худалдаа, үйлчилгээний ажилтнуудын ур чадвар, мэргэжлийн түвшинг дээшлүүлж үйлчилгээний соёл, стандартыг хангуулах сургалт, туршлага солилцох арга хэмжээг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.
- 2.3.3 Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжин "Бизнес хөгжлийн төв"-тэй болно.
- 2.3.4 Стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангахуйц тээвэр, агуулахын сүлжээг бий болгоно.

## 2.4 ХӨДӨӨ АЖ АХУЙ

**Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, малын үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулан малын эрүүл мэндийг хамгаалах, бэлчээр, тариалангийн талбайг нөхөн сэргээж, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх замаар хүн амын хүнсний хангамжийг сайжруулан эдийн засгийн өсөлтийг хангах:**

- 2.4.1 Малын үүлдэр угсааг шилмэл омгийн хээлтүүлэгчээр сайжруулж, малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.
- 2.4.2 Малчид болон боловсруулах үйлдвэр хоорондын шууд харилцааг дэмжиж, МАА-н түүхий эд, бүтээгдэхүүнийг борлуулах оновчтой сүлжээг орон нутагт бий болгоно.
- 2.4.3 Мах, сүү, шувууны аж ахуй болон эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж бэлчээрийн даацыг хамгаална.
- 2.4.4 Малчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх замаар хөдөөд ашигтай орлоготой, таатай амьдрах боломжийг бүрдүүлнэ.
- 2.4.5 Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалт, нэр төрлийг нэмэгдүүлж, өвөл, зуны хүлэмж байгуулах, аж ахуйн нэгж, өрх бүлийг дэмжинэ
- 2.4.6 Малын тэжээлийн үйлдвэр болон тариалалтын бизнес эрхлэгч иргэн, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжинэ.

**Мал сүргийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг оновчтой зохион байгуулан малын эрүүл мэндийг хамгаалах ажлыг эрчимжүүлэх:**

- 2.4.7 Мал сүргийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг оновчтой зохион байгуулан малын эрүүл мэндийг хамгаалах ажлыг эрчимжүүлнэ.
- 2.4.8 Малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн МЭҮН-ийн үйл ажиллагааг дэмжиж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ

## 2.5 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

**Байгальд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн, төрөлжсөн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх:**

- 2.5.1 Аялал жуулчлалын салбарын менежментийг боловсронгуй болгож, дотоод гадаадын аялагчдад зориулсан аяллын маршрутыг сонирхол хэрэгцээнд нь тулгуурлан төрөлжүүлж тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 2.5.2 Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж байгальд халгүй техник технологи ашиглахыг дэмжин жуулчны бааз, аялал жуулчлалын бүтээл /үзвэр/-үүдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- 2.5.3 Аялал жуулчлалын маршрутын дагуух түүх соёлын өвийг сурталчлан таниулах замаар жуулчдын урсгалыг нэмэгдүүлнэ.
- 2.5.4 Орон нутгийн иргэдийн амьдралд зөргөөр нөлөөлөх, жуулчдад чанартай стандарт үйлчилгээг үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд оруулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжинэ.
- 2.5.5 Спорт, эрүүл мэнд, явган алхалт, эко туризм, өвлийн аялал жуулчлал зэрэг нүүдэлчдийн өв соёлыг суртчилах аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг дэмжинэ.

## **ГУРАВ. ДЭД БҮТЭЦ, ТӨВ СУУРИНГЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

### **3.1 ЗАМ ТЭЭВЭР**

**Булган хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг төлөвлөж, зам тээвэр, барилга байгууламж, гэрэл цахилгаан, инженерийн шугам сүлжээ, газар ашиглалтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулж, иргэд тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэх:**

- 3.1.1 Орон нутгийн чанартай авто замын сүлжээнд хатуу хучилттай замын эзлэх хувийг нэмэгдүүлэх, замын байгууламжийн хүчин чадлыг сайжруулах замаар иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.1.2 Явган хүний зам, үерийн суваг, гүүр, авто машины зогсоол талбайг шинээр хийх болон сэргээн засварлана.
- 3.1.3 Орон нутгийн авто замын засвар ашиглалтыг сайжруулж аюул осолгүй зорчих боломжийг хангана.
- 3.1.4 Нийтийн зорчигч тээвэр болон такси үйлчилгээг тогтмолжуулж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### **3.2. ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ**

- 3.2.1 Шинээр үүсэх хороолол болон алслагдсан айл өрхийн эрчим хүчийг нэмэгдүүлж агаарын шугам болон дэд станц барина.

- 3.2.2 Гудамж, талбай, нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн чанарыг сайжруулж, шинээр гэрэлтүүлэг тавих ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.2.3 Гэр хорооллын гудамж бүрийг гэрэлтүүлэгтэй болгоно.

### 3.3 БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- 3.3.1 Орон нутгийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөж, бүтээн байгуулалтын чанарыг сайжруулах замаар иргэдийн амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.3.2 Булган хотыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу эрчимтэй хөгжүүлж, орон сууцны орчин нөхцөлийг сайжруулж, хотын тохижилт, соёлжилт, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлнэ.
- 3.3.3 Инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, орон сууц болон гэр хорооллыг хэрэглээний халуун устай болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 3.3.4 Амины орон сууцны халаалтын шийдэлд анхаарч, эрчим хүчинд хэмнэлттэй байгальд ээлтэй шинэ технологийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.3.5 Орон сууцжуулах хөтөлбөрийг үргэлжлүүлж худалдаа үйлчилгээ болон орон сууцны зориулалтаар хөрөнгө оруулалт хийх иргэн аж ахуйн нэгжийг дэмжинэ.

### 3.4 ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

**Хот, суурин газар ашиглалт, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, хаягжилтыг сайжруулан газар зохион байгуулалтыг боловсронгуй болгох:**

- 3.4.1 Хүн амын суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт газрын харилцааг боловсронгуй болгож иргэдийн оролцоотой газар зохион байгуулалтын төлөвлөлт хийж, газрын нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв зохистой ашиглана.
- 3.4.2 Иргэн бүрт газрыг үнэгүй өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж шинээр өмчлүүлэх газрын нөөцийг бодитоор тогтоож газар олголтыг хийнэ.
- 3.4.3 Булган суман дахь үл хөдлөх болон шинээр үүссэн нэгж талбаруудын хаягжуулалтын ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
- 3.4.4 Булган сумын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн хот, суурин газрын эдэлбэр газрын хил заагийг шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулна.
- 3.4.5 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж газрыг оновчтой, зүй зохистой, бүрэн дүүрэн ашиглана.

### 3.5 НОГООН ХӨГЖИЛ

**Байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөллөөс үүсэж буй ус, агаар, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах замаар эко системийн тогтвортой байдлыг хадгалж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх:**

- 3.5.1 Усны нөөцийн хомсдолоос сэргийлж бохирдлоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.5.2 Эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, ой, рашаан булгийг хамгаалах чиглэлээр бодлого хэрэгжүүлж, агаар, хөрсний бохирдлыг бууруулж, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлнэ.
- 3.5.3 Ойн сангийн хамтын эзэмшлийн менежментийг сайжруулж, ойжуулалт хийх, ойг нөхөн сэргээх ажлыг өргөжүүлж, төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг жил бүр нэмэгдүүлнэ.
- 3.5.4 Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.
- 3.5.5 Байгаль орчинд ээлтэй техник технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжинэ.
- 3.5.6 Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн өргэлтэд оруулахад чиглэсэн төсөл хөтөлбөртэй хамтарч хог хаягдлыг дахин боловсруулах менежментийг хэрэгжүүлнэ.
- 3.5.7 Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын дунд мод тарих хөдөлгөөн өрнүүлж, санаачилгыг дэмжин сумын ногоон байгууламжийг бүртгэлжүүлнэ.

## **ДӨРӨВ. НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

### **4.1 ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

**Нутгийн захиргааны байгууллагын бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгон авлигаас ангид, мэргэшсэн, хариуцлагатай байдлыг хангаж, бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хяналт үнэлгээ хийх үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэн нээлттэй ил тод засаглалын бодлогыг хэрэгжүүлэх:**

- 4.1.1 Төрийн албан хаагчдыг үе шаттай сургаж, мэргэшүүлэн ая тухтай ажиллах нөхцөл боломжийг сайжруулж, төрийн үйлчилгээний үр дүнг дээшлүүлнэ.
- 4.1.2 Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй болгож, иргэдийн мэдээлэл, үйлчилгээ авах боломж, нөхцөлийг сайжруулна. Цахим Монгол хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 4.1.3 Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.
- 4.1.4 Төрийн албанд авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулж, төр иргэний хамтын ажиллагааг сайжруулна.
- 4.1.5 Төрийн үйлчилгээнд иргэн, хувийг хэвшлийн оролцоот үнэлгээ, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлнэ.

4.1.6 Төрийн байгууллагад жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүх түвшинд жендерийн бодлого хэрэгжүүлнэ.

## 4.2 НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ

**Нийгмийн хэв журмыг сахиулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн иргэнд ээлтэй, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх:**

4.2.1 Архи, тамхины зөв зохистой хэрэглээний соёлыг төлөвшүүлэх ажлыг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлж, иргэдийн хандлагыг өөрчилж эрүүл хотыг бүтээнэ.

4.2.2 Гэр хороолол, гудамж талбайг камержуулах, төв суурин газрын үйлчилгээний газруудын гэрэлтүүлэг, аюулгүй байдлын хяналтын сүлжээг сайжруулна.

4.2.3 Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж "Түр хамгаалах байр"-ны үйл ажиллагааг дэмжин ажиллана.

4.2.4 Гэмт хэрэг хэв журмын зөрчлийн хувийг багасгаж иргэд амгалан тайван айл аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.

4.2.5 Иргэдэд эрх зүйн боловсрол олгох ажлыг эрчимжүүлж хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан хэрэгжилтийг хангана.

## 4.3 БАТЛАН ХАМГААЛАХ

**Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх тогтолцоог бэхжүүлж, орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэл, эмзэг байдал, хохирлыг бууруулах олон нийтэд тулгуурласан менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх:**

4.3.1 Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж хүүхэд залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил олгох ажлыг олон хэлбэрээр зохион байгуулна.

4.3.2 Болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, сайн дурын бүлэг, иргэдийн идэвх санаачилгыг дэмжинэ.

4.3.3 Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулж гамшгаас хамгаалах болон удирдах бүрэлдэхүүний дадлага сургуулилтыг хийж, материаллаг баазыг нэмэгдүүлнэ.

## 4.4 ТӨСӨВ САНХҮҮ

**Орон нутгийн төсвийг төлөвлөх, батлах, зарцуулах үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгож, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх:**

- 4.4.1 Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, төсвийн зардлын ил тод байдлыг хангана.
- 4.4.2 Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хөтлөлт, олон улсын стандарт нэвтрүүлэлтийг сайжруулах замаар төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, удирдлагын бүх шатанд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн оновчтой шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ.
- 4.4.3 Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж бүх шатанд шилэн байлгана.

#### 4.5 ГАДААД ХАРИЛЦАА

Орон нутгийн хөгжлийг дэмжих бүхий л чиглэлээр гадаад, дотоодын томоохон хот, аймгуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх:

- 4.5.1 ОХУ, Солонгос, Япон зэрэг улсуудтай эхлүүлсэн хамтын ажиллагааг үргэлжлүүлж, боловсрол, эрүүл мэнд, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтын чиглэлд үйл ажиллагааг өргөн хүрээгээр үргэлжлүүлнэ.
- 4.5.2 Тэргүүн туршлагатай аймаг, хотуудын үр дүнтэй ажил, оновчтой санал санаачилгыг өөрийн орон нутгийн түвшинд зохицуулан, тэдний арга туршлагыг хэрэгжүүлнэ.